



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/663.

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Увс аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 42 дугаар шийдвэрийн дагуу Жаргалант сумын Алагтолгой багийн 1 дүгээр гудамжны 48 тоотод байрлах, 720.0 метр квадрат газрыг Пүрэвийн Болормаа /ПЮ73110304/-д гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Жаргалант сумын 2017 оны 10 сарын 27-ны өдрийн А/235 дугаар захирамжийн Пүрэвийн Болормаад холбогдох 3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/663 Ch  
02 03281